



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан тайлан

Аудитын код: ХОА-2026/005/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Н.Батзул Утас: 70432545 Цахим хаяг: batzul.n@audit.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	6
3.1 ЗӨВЛӨМЖ	6
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	8
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ.....	8

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026-03-13 № 246
тэнэй 2026-02-11 ны № 09 -т

ЖАРГАЛАНТ СУМЫН БААТАРХАЙРХАН
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.ТУУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өрхийн эрүүл мэндийн төв нь орон нутгийн өмч ашиглан зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрээр ажиллаж байгаа боловч эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг эрх бүхий этгээдээр батлуулаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Жаргалант сумын Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төв нь гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас өмнөх оны авлага 25,552.0 мянган төгрөг, тайлант оны гүйцэтгэлээр 485,160.8 мянган төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газраас тогтмол зардлын санхүүжилт 23,617.9 мянган төгрөг, төсөл хөтөлбөр болон бусад эх үүсвэрээс 9,531.1 мянга нийт 543,861.9 мянган төгрөгийн мөнгөн орлого бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд

8426050594

542,837.8 мянган төгрөгийг зарцуулсан, 249,920.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Жаргалант сумын ОНХС-н хөрөнгө оруулалтаар болон Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

"Баатархайрхан-Өрх" зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн үүсгэн байгуулагчдын 2021 оны 01 дугаар сарын 05-ний өдрийн хурлаар гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан, өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 8 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр гишүүнчлэлийг баталж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 98.2 мянган төгрөг байсныг 287.0 мянган төгрөг болгон өөрчилсөн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 30
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	372,749	1,396,793.73
1.1.2	Дансны авлага/ЭМДСан/	25,552,083	5,834,181.50
1.1.3	Татвар, НДШ. Цалингийн авлага	61,932	159,348.55
1.1.4	Бусад авлага /Гэрэл цахилгаан/	2,662	1,700,201.76
1.1.6	Бараа материал	68,719,141	57,632,185.59
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	94,708,567	66,722,711.13
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	593,460,802	802,599,329.34
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	593,460,802	802,599,329.34
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	688,169,369	869,322,040.47
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	5,858,319	
2.1.1.3	Татварын өр	5,220,220	11,176,902.67
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,078,539	11,176,902.67
2.2	Өр төлбөрийн нийт дүн	11,078,539	11,176,902.67
2.3	Эздийн өмч	38,925,177	38,925,177.00
2.3.1	Өмч: - төрийн	38,925,177	38,925,177.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,636,655	10,636,655.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	358,054,871	358,054,871.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг/алдагдал/	193,973,058	269,474,127.00
2.3.10	Тайлант үеийн ашиг/алдагдал/	75,501,069	181,054,307.80
2.3.11	Эздийн өмчийн дүн	677,090,830	858,145,137.80
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	688,169,369	869,322,040.47

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 30
1	Борлуулалтын орлого (цэвэр)	474,535,279	543,861,934.00
3	Нийт ашиг (алдагдал)	474,535,279	543,861,934.00
8	Бусад орлого/Үнэ төлбөргүй авсан бараа/	6,973,665	249,920,336.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	406,007,875	612,727,962.20
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	26,412,224	181,054,307.80
20	Татварын дараах ашиг (алдагдал)	26,412,224	181,054,307.80
24	Орлогын нийт дүн	26,412,224	181,054,307.80

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	38,925,177	10,636,655.00	358,054,871.00	269,474,127.00	677,090,830.00
3	Залруулсан үлдэгдэл	38,925,177	10,636,655.00	358,054,871.00	269,474,127.00	677,090,830.00
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	38,925,177	10,636,655.00	358,054,871.00	269,474,127.00	677,090,830.00
11	Залруулсан үлдэгдэл	38,925,177	10,636,655.00	358,054,871.00	269,474,127.00	677,090,830.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				181054307.8	181,054,307.80
17	2025 оны 12-р сарын 30-ний үлдэгдэл	38,925,177	10,636,655.00	358,054,871.00	450,528,434.80	858,145,137.80

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 30
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	474,535,279	543,861,934
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого/Хүү/	83,955	168,597
	НДСангаас авсан ХЧТА-ын тэтгэмж	1,225,179	-
	ЭМ ДСангийн санхүүжилт	76,141,250	121,255,238
	Бусад төсөл хөтөлбөр	2,000,000	3,000,000
	Татаас, санхүүжилтийн орлого/НИТЗардал/	373,371,595	389,457,671
	Бусад мөнгөн орлого	21,713,300	29,980,428.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	474,736,281	542,837,890
	Ажиллагчдад төлсөн	270,281,231	302,181,344
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	79,711,187	88,102,346
	Бараа материал худалдан авахад төлсөн	51,807,950	36,636,552
	Ашиглалтын зардалд төлсөн	21,221,810	26,623,159
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,830,000	4,973,000
	Бусад төсөл арга хэмжээ	2,000,000	3,000,000
	Татварын байгууллагад төлсөн	26,226,998	35,490,462
	Шуудан холбоо интернэт	1,610,300	2,838,000
	Бусад мөнгөн зарлага	18,046,805	42,993,027
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(201,002)	1,024,044
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	479,002	1,024,045
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	573,749	372,749
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	372,749	1,396,794

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,028.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 7,028.7 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 7,028.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан хэдий ч шинж чанарын хувьд материаллаг бус байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

3.1 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Хөрөнгийн ангилал, бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлд зориулалт, ашиглалт адилхан бараа материал үндсэн хөрөнгийг бүртгэсэн зөрчил илэрсэн нь НББОУС 16-д зааснаар үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, түрээслүүлэх ба удирдлагын хэрэгцээнд ашиглаж буй, нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах биет хөрөнгийг үндсэн хөрөнгө гэх бөгөөд Үндсэн хөрөнгө нь дараах шинж чанарыг агуулна.

1. Борлуулах бус үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах
2. Удаан хугацаанд ашиглагдахын зэрэгцээгээр элэгдэлд ордог
3. Биетэй бодитойгоор оршдог
4. Тодорхой хэмжээний өртөгтэй байна.

гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материал, болон үндсэн хөрөнгө дансанд аль алинд нь бүртгэлтэй байгаа хөрөнгийг дээр дурдсан шинж чанараас нь хамааруулан ангиллын дагуу үнэн зөв бүртгэж 2026 оны эхний хагас жилд багтаан залруулан тайлагнах

3.1.2 Бараа материалтай холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын бараа материалын бүртгэлд оны эцэст 18 тн нүүрс бүртгэлтэй байгаа бөгөөд их хэмжээний нөөцийг бэлтгэж, дараа жилийн халаалтын улирал эхлэх хүртэл хадгалж байгаа Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант оны эцэст нүүрсний нөөцийг өмнөх саруудын гүйцэтгэлд үндэслэн нөөцлөх, удаан хугацаанд хадгалж чанар, илчлэгт өөрчлөлт орох магадлалтай тул тооцоо, төлөвлөгөөтэй нөөц бүрдүүлэх шаардлагатай.

3.1.3 Хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд оруулах "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэл"-ийг цахим сайтад 2025 оны 11 сард бүргүүлж мэдээлэл оруулж эхэлсэнтэй холбоотой 1-3 дугаар улирлын мэдээллийг мэдээлээгүй, 4 дүгээр улирал дээр нөхөж мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1-д заасан зарчмууд, 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн дагуу мэдээлэл мэдээллийг заасан хугацаанд, бүрэн гүйцэт, үнэн зөв мэдээлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан

тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуульд	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Баатархайрхан ӨЭМТ	Бараа материал, хөрөнгийн ангилал буруу	1	1,528.7						1,528.7		
	Нүүрсний нөөц өндөр	1	5,500.0						5,500.0		
Нийт дүн		3	7,028.7						7,028.7		

4.2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9
Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлээгүй	1	0				0	1	-
ДҮН	1	0				0	1	0

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			